

социализмын ролийг улам өндөржүүлж, социалист орнуудын найрамдал, хамтын ажиллагааг бүх талаар бэхжүүлж хөгжүүлэх явдал нэн чухал ажээ.

БНМАУ Азийн ууган социалист орны хувьд Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын найрамдалд харилцааг өргөтгөж, хамтран ажиллах явдлыг өрнүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар ихээхэн хүч чармайлт тавьж байдаг билээ. БНМАУ энэ чигт юуны өмнө Азийн бусад социалист орон ЗХУ, БНХАУ, БНАСАУ, БНСВУ, БНАЛАУ, БНКАУ болон Энэтхэг зэрэг энхийг эрхэмлэгч бүх улсуудтай хамтран ажиллахыг эрхэмлэн үзэх гадаад бодлогоо тууштай явуулж байна.

<sup>1</sup> **М. С. Горбачев.** Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ., 1988., х. 221

<sup>2</sup> «Проблемы Дальнего Востока» 1987., No 6, с. 3

<sup>3</sup> **Ж. Батмөнх,** Азийн аюулгүй байдалд нийтээр анхаарал тавья. «Энх тайван социализмын асуудал», 1987, No 6. х. 5

<sup>4</sup> **М. С. Горбачев.** Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ. х. 212

<sup>5</sup> **М. С. Горбачев,** Избранные речи и статьи Т. 4. М., 1987, с. 9—35

<sup>6</sup> **М. С. Горбачев,** Индонезийн «Мердека» сонины асуудалд өгсөн хариулт. «Үнэн», 1987—7—24

<sup>7</sup> Заявление Генерального секретаря ЦК КПСС М. С. Горбачева по Афганистану. «Правда», 1988. II—11

<sup>8</sup> Заявление Наджибуллы. - «Правда» 1988. 11-10

<sup>9</sup> Визит Генерального секретаря ЦК КПСС М. С. Горбачева в США. М., 1987, с. 32—61

<sup>10</sup> **Ж. Батмөнх,** Монголын ард түмэнд хандаж радио, телевизээр хэлсэн үг. -«Үнэн», 1988—1—1

**ҮНДЭСНИЙ ЭВЛЭРЛИЙН  
БОДЛОГО БОЛ АФГАНЫ АРД  
ТҮМНИЙ ЭНХ ТАЙВАН  
ХӨГЖЛИЙН ЗАМ МӨН**

М. ХУРМЕТХАН  
Ж. ОЮУНСҮРЭН

1987 оны нэгдүгээр сард АААН-ын Төв Хорооны өргөтгөсөн онц бүгд хурал болж АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажибуллагийн тавьсан «Нийт үндэсний эвлэрлийн бодлогыг хэрэгжүүлэхэд АААН-ын гүйцэтгэх зорилтын тухай» илтгэлд Афганистанд үндэсний эвлэрэл тогтоох бодлогыг зарлаж тунхагласан юм.

Эвлэрэл тогтоох зарчимд юуны түрүүнд «байлдааны гал зогсоох, Афганистаны одоогийн болон ирээдүйн асуудлыг шийдвэрлэсэн нөх-

цөлд зэвсэгт тэмцлээс болон цус урсгах явдлаас татгалзах, улс төрийн бүтцэд хийгээд эдийн засгийн амьдралд бүх ард түмнийг шударгаар төлөөлөх зарчмыг хангах; улс төрийн өмнөх үйл ажиллагааны төлөө хавчиж мөрдөхөөс татгалзан, бүх нийтээр өршөөл үзүүлэх; түүхэн, үндэсний болон соёлын уламжлалыг хамгаалан арвижуулахыг»<sup>1</sup> заасан билээ.

Үндэсний эвлэрэл тогтоох бодлогын гол зорилго нь гэвэл Афганистан оронд энх тайван, аюулгүй байдлыг хангах, хувьсгалын байлдан ололтыг улам хөгжүүлэх, АААН-ын үйл ажиллагааны программыг бүрэн хэрэгжүүлэх, Афганистаны биеэ даасан, ардчилсан, дэвшилт Хөгжлийг хангах, Афганистанд тогтвортой байдлыг бий болгон, ЗХУ-тай тогтоосон найрамдалд үнэнч ардын засгийг бэхжүүлэх явдал юм.

Энэхүү бодлогын дагуу Афганистанд асар их өөрчлөлт гарсаныг АААН-ын нийт үндэсний бага хурал дээр АААН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Нажибуллагийн тавьсан илтгэлд тусган харуулсан юм.<sup>2</sup>

Үндэсний эвлэрэл тогтоох бодлогын хүрээнд дотоод бодлогын салбарт гэвэл сөрөг хүчнийхэн болон төвийг сахисан хүчинтэй зоригтой бөгөөд ил шууд хэлхээ холбоо тогтоох нь чухал гэж үзсэн юм. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн асар их ажлыг өнгөрсөн хугацаанд Афганистан оронд хэрэгжүүлэв. Афганистаны удирдлагын улс төрийн шинэ бодлого-үндэсний эвлэрэл тогтоох бодлогын дагуу зэвсэгт хүчний хүрээнд дангаараа бүх нутаг дэвсгэрт 1987 оны нэгдүгээр сарын 15 наас гал зогсоосон юм. Байлдааны гал зогсоох нь чухал бөгөөд шаардлагатай хэрэг мөн бөгөөд энэ нь зөвхөн нэг талаас хамаарахгүй нь тодорхой билээ. Гал зогсоосон нөхцөлд сөрөг хүчнийхнийг ял шийтгэлээс хэлтрүүлж, төр, олон нийтийн удирдах байгууллагуудад сонгогдох эрхээр хангах, гэм буруугаа ойлгосон улс төрийн хоригдлуудыг суллах зэрэг энэрэнгүй алхам хийж эхэлсэн билээ.

Үндэсний эвлэрлийн бодлогыг хэрэгжүүлсэн хугацаанд Афганистанд ямар өөрчлөлт гарав гэсэн асуултад БНАфГУ-ын ерөнхийлөгч Нажибулла «Үндэсний эвлэрлийн бодлого манай орны хөгжлийн түүхэнд нэгэн шинэ хуудас болж орлоо. Есөн жил гаруйн туршид дайн дажинд нэрвэгдсэн афганчууд одоо энэхүү аймшигт гамшгаас ангижрах замыг нэгэнт олж харлаа»<sup>3</sup> гэж хариулжээ.

Эвлэрэл тогтоох бодлогыг хэрэгжүүлэх явцад Афганистаны дотоод амьдралд улс төрийн хэд хэдэн чухал үйл явдлууд болов. Тус улсын үндсэн хууль батлагдан Афганы ард түмний өмнө тусгаар тогтнолоо бэхжүүлэх, улс орны газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогт нол, олон улсын тавцанд түүний гүйцэтгэх үүрэг, нэр хүндийн өсөлт, нийгмийн шударга ёс, тэгш эрхийг бэхжүүлэх, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, хүн амын амьдралын түвшинг сайжруулах гэсэн өндөр зорилтуудыг тавилаа.

Орон нутгийн эрх мэдэл бүхий байгууллагууд болон үндэсний эвлэрлийн тусгай комиссуудын ажил БНАфГУ-д улам амжилттай явагдаж байна. Одоо тэдний ажилд хот, хөдөө, хошуу, тосгонд 90 мянга гаруй идэвхтнүүд оролцож байгаа бөгөөд тэдний нэлээд нь саяхан болтол ардын засгийн эсрэг тэмцэж байжээ. Афганистанд ажиллаж байгаа үндэсний эвлэрэл тогтоох 3370 комиссын бүрэлдэхүүнд засгийн газрын эсрэг байсан зургаан мянга орчим хүн ажиллаж тэдний дөрвөн зуу нь төрийн эрх барих дээд болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын депутат болсон байна.<sup>4</sup> Эвлэрэл тогтоох бодлогыг хэрэг-

жүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан олон хууль зарлиг, тухайлбал бүх нийтээр цэргийн алба хаах тухай, хувийн хөрөнгө оруулалтын Тухай, хөдөлмөрийн тухай, Хэвлэлийн тухай, улс төрийн намуудын тухай хууль гаргасны зэрэгцээ өршөөл үзүүлэх зарлигийн дагуу улс төрийн 12 мянган хоригдлыг суллаж, олон хүний хоригдох хугацааг богиносгожээ. Мөн хугацаанд Зэвсэгт сөрөг бүлэглэлүүдийн дөчин мянга гаруй гишүүн ардын засгийн талд орж, 114 мянган хүн гал зогсоох болзлыг дагаж мөрдөх тухай протоколд гарын үсэг зурснаар эвлэрэл тогтоох бодлогыг дэмжиж байгаагаа илэрхийлжээ. Пакистан, Иран дахь хуарангуудаас 116 мянган афган хүн төрөлх нутагтаа буцаж ирлээ. Афганистан цаашид ч ирж байгаа, ирэх дүрвэгчдийг хүлээн авахад бэлэн байна. Дүрвэгчдийн хэрэг эрхлэх газар байгуулагдан дүрвэгч асан сая хүнийг хүлээн авах боломжтой байна. Тэдэнд материаллаг тусламж үзүүлэн, эмнэлгийн шинжилгээ хийж, төрөлх муждаа очих, ах дүү нартайгаа уулзахад туслаж байна.

Энх тайвны бүс байгуулсан нутаг дэвсгэрт 165 гацаа суурин, хоёр муж, 1150 тосгон хамрагдаж байгаа бөгөөд тэдгээрт 3 сая шахам хүн аж төрж байна.<sup>5</sup>

Олон арван тосгонд орон нутгийн захиргааны эвслийн байгууллагууд байгуулагдан ажиллаж байна. Яваандаа засгийн ийм хэлбэр бүх хошуу, мужид дэлгэрэх юм. Ингэж улс төрийн янз бүрийн хүчнүүд болон хүн амын давхарга оролцож буй энэ ажиллагаа доороосоо дээшээ хөгжиж байна: хошуу тосгодоос засгийн төв байгууллагуудад 4 мужийн сайдаар урьд нь сөрөг бүлэглэлүүдийн удирдагч байсан хүмүүсийг сонгосон байна. Тус оронд бүх ардчилсан ба эх оронч хүчнүүдийн бодит эвслийг байгуулах замд БНАфГУ-ын Хувьсгалт Зөвлөлөөс гаргасан шинэ намуудыг байгуулах, ил байдалтай болгох тухай хууль чухал алхам боллоо. Хувийн үйлдвэрийн эзэд, лалын шашны зүтгэлтнүүд, тариачид болон нийгмийн зарим давхаргууд өөрийн улс төрийн байгууллагаа байгуулах бодолтой байна. Улсын одоогийн удирдлагын үзэж байгаагаар тэд нийгмийн хөгжлийн янз бүрийн үзэл бодлын ойлгоц, онолыг баримталж, стратеги, тактикийн асуудлуудаар зөрөлдөж буй боловч афганы нутагт энх амгалан байдлыг түргэн хугацаанд тогтоох, үндэсний тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа бэхжүүлэх, бүх улс оронтой, нэн тэргүүнд Афганистантай хөрш зэргэлдээ оршдог улсуудтай тогтоосон найрамдал, хамтын ажиллагааны зарчмыг баримтлах ерөнхий зорилго тэднийг нэгтгэх юм.

АААН-ын нийт үндэсний П бага хурал тус орны түүхэнд нэгэн шинэ хуудас болж оров. 1987 оны 10-р сарын 18—20-нд БНАфГУ-ын нийслэлд хуралдсан АААН-ын нийт үндэсний бага хуралд бүх мужийн намын байгууллагуудын 677 төлөөлөгчид оролцов. Тэдний дунд ажилчид, тариачид, цэргийн албан хаагчид, оюутнууд, соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүд байв. Бага хурлаар үндэсний эвлэрлийн бодлогын хэрэгжилтийн явц, түүнийг хурдасгах намын бодлого, АААН-ын үйл ажиллагааны программд оруулах зарим өөрчлөлтүүд, намын эгнээг бэхжүүлэх арга хэмжээ, үндэсний эвлэрлийн бодлогын нөхцөл дэх эдийн засгийн хөгжлийн асуудлыг авч хэлэлцсэн юм.

«Үндэсний эвлэрлийн явцыг хурдасгах талаар намаас тавих зорилт, АААН-ын үйл ажиллагааны Программд зарим өөрчлөлт оруулах тухай» гол илтгэлийг АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажибулла тавьсан юм. Мөн түүнчилэн АААН-ын Төв Хорооны

Улс төрийн товчооны гишүүд, орлогч гишүүд хавсралт илтгэлүүд тавьж, бага хурлаар хэлэлцсэн асуудал, илтгэлүүдтэй холбогдуулан бүгд 31 төлөөлөгч үг хэлэв.

Нөхөр Нажибулла илтгэлдээ үндэсний эвлэрлийн бодлогыг зарлан явуулах болсон шалтгаан, зорилго, мөн чанар, хэрэгжиж буй явц, цаашдын зорилт, хэрэгжүүлэх арга хэлбэр, тохиолдож буй бэрхшээл, даван туулах зам, нөхцөл боломжийн талаар дэлгэрэнгүй ярьсан билээ. «АААН-ын үйл ажиллагааны программ нь 4-р сарын хувьсгал нь ардчилсан өөрчлөлт хийх замаар үндэсний дэвшлийг хангаж өгсөн үндэсний ардын ардчилсан хувьсгал болохыг тодорхойлж байна. Манай хувьсгал нь пролетарийн ч биш, социалист ч биш юм. Дөрөвдүгээр сарын хувьсгал нь жинхэнэ амьдралаас урган гарсан юм» гэж Нажибулла хэлэв. Үндэсний эвлэрлийн бодлого нь бүх ард түмний шинж чанарыг агуулж байна. Ийм учраас энэ бодлогыг зохион байгуулагч бөгөөд гүйцэтгэн биелүүлэгч нь АААН ба хувьсгалт засаг юм.<sup>6</sup>

АААН-ын нийт үндэсний бага хурлын дараахь таван жилийн гол ололт нь Дөрөвдүгээр сарын хувьсгалын урагшлах хөгжил, түүний бэхжилт бөгөөд намын үйл ажиллагаа нь гол төлөөлөгч хүч болохыг Нажибулла тэмдэглэв. Бага хурал үндэсний эвлэрлийн бодлогыг үндсэн хоёр үе шатанд хувааж болохыг тэмдэглэн, хэрэгжиж байгаа байдлыг тодорхойлов.

**Нэгдүгээр үе шатанд** үндэсний эвлэрлийн бодлогыг боловсруулан зарлаж, хууль зүйн үндсийг бий болгов. Тухайлбал, олон намын системтэй байх тухай хууль, хувийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг батлан гаргаж, газар усны шинэтгэлийн тухай хуульд газрыг хувьдаа эзэмших хэмжээг нэмэгдүүлэх тухай өөрчлөлт оруулсан, улсын үндсэн хуулийг нийт ард түмнээр хэлэлцүүлсэн, эвслийн засаг захиргааг доод шатнаас байгуулах эхлэл тавигдаж, сөрөг хүчнийхэнд төр, засгийн албан тушаалуудаас өгөхөд бэлэн байгааг мэдэгдсэн зэрэг нь багтаж байна.

**Хоёрдугаар үе шатанд** үндэсний эвлэрлийн бодлогын гол зорилтуудыг практикт хэрэгжүүлэх ажил зохиохыг тодорхойлон, хэрэгжүүлж байна. Нийт үндэсний П бага хурлын шийдвэрийн дагуу Бүгд Найрамдах Ардчилсан Афганистан Улсын нэрийг 1987 оны XI сард хуралдсан Лоия Жиргаар Бүгд Найрамдах Афганистан Улс гэж нэрлэх болов. БНАфгУ-ын үндсэн хуулийг баталж, БНАфгУ-ын ерөнхийлөгчөөр нөхөр Нажибуллаг сонгов. Үүнээс гадна энэхүү шатанд дараахь зорилтуудыг хэрэгжүүлэхээр зааж байна. Үүнд:

- Зүүний болон ардчилсан хүчнүүдийн эвсэл үүсгэн байгуулах ажлыг дуусгаж, янз бүрийн намуудтай хамтран ажиллах механизмыг боловсронгуй болгох;
- Төв, орон нутагт эвслийн засгийн газар болон засаг захиргааг байгуулах;
- Дүрвэгсдийг эх орондоо буцаж ирэх үйл явцыг түргэтгэх;
- Намын - их хурлыг хийх, Дөрөвдүгээр сарын хувьсгалын 10 жилийн ойг тэмдэглэх зэрэг юм<sup>7</sup>.

Бага хурал үндэсний эвлэрэл тогтооход хүчтэй, нэр хүнд бүхий, нягтарсан АААН-гүйцэтгэж чадна гэдгийг заав. Бага хурал намын эгнээнд оршиж байгаа дутагдлын тухай ил тод шүүмжлэн ярилцлаа.

Одоо АААН-ын эгнээнд 185 мянган гишүүн байна. Намын анхан шатны байгууллага улс орныг бүхэлд нь хамарч 6600 болжээ. Болов-

сон хүчний ажлыг эрс сайжруулах зорилт дэвшүүлэв. Боловсон хүчнийг шилж сонгох, хуваарилах, дэвшүүлэхдээ гагцхүү тэдний ажил хэрэгч, зарчимч, шударга чанарыг харгалзах зарчмыг хатуу баримтлахыг заажээ.

Олон нийтийн байгууллагуудтай ажиллах явдлыг сайжруулахын чухлыг тэмдэглэв. Олон нийтийн байгууллагуудын эгнээг өсгөх, тэдний ажилд хэвшил болсон хэлбэрдэх явдлыг арилгах, ажлыг нь идэвхжүүлэхийг тэмдэглэв. Ялангуяа, эмэгтэйчүүдийн байгууллагын ажлыг идэвхжүүлэхийг онцгой анхаарав.

Бага хурал дээр намын эгнээг бэхжүүлэхээс гадна зэвсэгт хүчнийг бэхжүүлэх асуудалд нэг адил чухалчлан хандлаа. Афганистаны зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн намын хоёр бага хурлын хоорондох 5 жилийн хугацаанд 127 мянган хүнээр нэмэгдсэн байна.<sup>8</sup> Цаашид зэвсэгт хүчний зохион байгуулалт, байлдах чадварыг дээшлүүлэхийг заав. АААН-ынх П их хурлыг Дөрөвдүгээр сарын хувьсгалын 10 жилийн ойн босгон дээр хуралдуулахаар шийдвэрлэсэн юм.

1986 оны 3-р сараас таван жилийн хугацаанд зориулсан (1986—1987 1990—1991) улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг биелүүлж эхэлсэн юм. АААН-ын Төв Хороо, БНАфГУ-ын засгийн газрын баталсан «Таван жилийн төлөвлөгөөний үндсэн чиглэлүүд»-д үйлдвэрийн газруудыг нэн тэргүүнд сэргээн босгож, шинэчлэх, техникээр шинэчлэн тоноглох; барилга байгууламжийн ажлыг түргэсгэх, барьж дуусгах; одоо ажиллаж байгаа үйлдвэрийн газруудын үр ашгийг дээшлүүлэх; ХАА-н хөгжилд бүх талаар тусламж үзүүлэх зэрэг маш чухал зорилтуудыг тавьсан байна. БНАфГУ-ын Засгийн газар улс орны хөгжлийн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг (1986—1990) боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх үйлсдээ орсон билээ. Түүнд, тухайлбал, анхдугаар таван жилийн хугацаанд нийт үндэсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 25% -иар өснө гэж заажээ. (Өнгөрсөн 5 жилд энэ үзүүлэлт зөвхөн 14 % иар өсчээ). Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 38%, ХАА-н бүтээгдэхүүний хэмжээ 14—15 хувиар өснө. Үндэсний орлогын өсөлтийн хурд таван жилийн хугацаанд 26 хувь буюу 1980—1985 оны үетэй харьцуулахад 2 дахин өсчээ. Үндэсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 1986 оныхтой харьцуулахад 1987 онд 3,3 хувь илүү, үндэсний орлого 3,6 хувь өссөн. Их барилгад үлэмж хэмжээний амжилт гарч жилийн төлөвлөгөө нь 113,8 хувиар биелэгджээ. Өнгөрсөн таван жилд Афганистанд 30 гаруй үйлдвэрийн газар шинээр байгуулж зарим үйлдвэр их төлөв хувийн болон холимог секторын үйлдвэрийг сэргээн босголоо, Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ 3,7 хувиар нэмэгдэж, 138 мянган тонн улаан буудай бэлтгэлээ. Ийм үр дүн хувьсгалын өмнө ч хувьсгалаас хойш ч гарч байгаагүй юм. Энэ бүхэн эдийн засгийн хөгжлийг харуулж байгаа юм.

АААН, төр залуучуудыг суралцах боломжоор хангахын тулд олон зүйл хийж байна. Зөвхөн Кабулын их, дээд сургууль, техникум, дунд сургууль, тэрчлэн лицейн ахлах ангиудад 100 мянган хүн суралцаж байна.<sup>9</sup> Одоо тус оронд ерөнхий боловсролын 1241 сургуульд 800 мянган хүүхэд суралцаж байна.<sup>9</sup> Техник мэргэжлийн сургууль, техникум, дээд сургуульд 17 мянган хүн суралцаж байна. Хувьсгалын дараа хөдөлмөрчдийг бичиг үсэгт сургах асуудалд их анхаарал тавив, Бичиг үсэгт сургах 25 мянган курст 516 мянган хүн суралцаж байгаа бөгөөд 2 сая илүү хүн суралцаж төгссөн байна.<sup>10</sup>

БНАфгу гадаад бодлогын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. БНАфГУ одоо дэлхийн бараг 100 оронтой байнгын дипломат харилцаатай юм. Афганы ард түмний эх орондоо шинэ нийгэм байгуулахын төлөө хувьсгалт тэмцлийг ЗХУ, ах дүү социалист бусад орон бүх талаар дэмжин сэтгэл харамгүй тусламж үзүүлж байна. Зөвлөлүүдийн орны тусламж дэмжлэг нь тус орны амьдралд шийдвэрлэх хүчин зүйл болж байгаа юм. Зөвлөлт-Афганы хамтын ажиллагааны үр дүнд байгуулсан 100 гаруй үйлдвэрийн газарт Афганистаны аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 60 хүртэл хувийг үйлдвэрлэн гаргаж байна. ЗХУ-ын тусламжаар 90 гаруй үйлдвэр аж ахуйн газар баригдаж байна. Сүүлийн үед Зөвлөлт-афганы хамтын ажиллагааны хэмжээ мэдэгдэхүйц өсч, аж үйлдвэрийн хэд хэдэн чухал барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болжээ. Афганы хувийн үйлдвэрийн эзэдтэй худалдаа эдийн засгийн талаар хамтран ажиллаж байна. Эрдэм шинжилгээний байгууллага, соёл, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагаа идэвхжсэн байна.

Зөвлөлт орны бүгд найрамдах улс, муж, хотуудын хооронд шууд харилцаа тогтоох явдал харилцааны практикт батжиж байна.

«Зөвлөлтийн хязгаарлагдмал тооны цэргийн интернационалч дайчид Афганы ард түмний шударга тэмцэлд үнэлж баршгүй тусламж үзүүлж байгааг онцгойлон дурьдах хэрэгтэй. Тэд амь биеэ үл хайрлан мянга мянган хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшдийг аюулаас аварч, ажилчид үйлдвэртээ ажиллах, тариачид ургац хураах, хүүхдүүд сургуульдаа явах бололцоог олгов. Зөвлөлтийн ард түмэн, түүний интернационалч дайчдын үзүүлсэн ба үзүүлж байгаа тусламжинд афганы ард түмэн үүрд талархан баярлаж байх болно»<sup>11</sup> гэж АААН-ын нийт үндэсний II бага хурал дээр АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нажибулла мэдэгдсэн билээ.

БНАфГУ одоо дэлхийн 50 оронтой худалдааны харилцаатай байна. 1978—1986 онд БНАфГУ-аас капиталист орнуудад экспортлох каракуль хивс, хатаасан жимс, арьсан түүхий эд, ноос болон афганы бусад үнэт бараа 2 дахин (96 саяас 41 сая доллар), гадаадаас авах аж үйлдвэрийн бараа хэд дахин багассан байна. (АНУ-аас 15—5, Англиас 22 - 3, ХБНГУ-аас 47—17 сая доллар хүртэл). Афганистанас социалист орнуудад, юуны түрүүнд ЗХУ-д нийлүүлэх байгалийн хий, хөвөн, ноос, арьсан түүхий эд, жимс өртгийн үзүүлэлтээр бараг 4 дахин (122 - 435 сая доллар), тэднээс авах аж үйлдвэрийн бараа 6 дахин (1 12 607 сая доллар) өсчээ. 1986 онд БНАфГУ-ын гадаад худалдааны гүйлгээ 1978 оныхтой харьцуулахад гол төлөв социалист орнуудтай хийсэн худалдааны өсөлтийн ачаар 2 дахин нэмэгджээ (743—1450 сая доллар.)<sup>12</sup>

Монгол, Афганистан хоёр улсын ах дүү ард түмнүүдийн найрамдал, хамтын ажиллагаа нь улам эрчимтэй хөгжиж байна. Хоёр орны харилцааг шинэ шатанд гаргасан найрамдал, хамтын ажиллагааны тухай 1983 оны Гэрээ нь Монгол-Афганы харилцааны улс төр, эрх зүйн үндэс болж байна. 1981 —1985 онд нам, улс, олон нийт хүүхэд залуучуудын байгууллагын шугамаар манай улсад БНАфГУ-аас 250 гаруй зочин төлөөлөгчид айлчилж, Монголын ард түмний социалист байгуулалтдаа элж буй ололт амжилттай танилцаж харилцан туршлага солилцсон юм. Сүүлийн жилүүдэд энэ тоо улам өсөн нэмэгдэв.

БНМАУ-ын Засгийн газрын урилгаар АААН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, БНАфГУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга

Султан Али Кештманд БНМАУ-д 1987 оны долдугаар сарын 7—13-нд албан ёсны, найрсаг айлчлал хийв. Нөхөр С. А. Кештманд Улаанбаатар, Эрдэнэт хотод аж үйлдвэр, хөдөө аж ахуй, соёлын газруудаар очиж, Монголын ард түмний аж амьдрал, шинэ нийгмийг бүтээн байгуулах үйлсдээ олсон ололт амжилттай танилцсан билээ. БНАфГУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга С. А. Кештманд хэлэхдээ: «БНАфГУ, БНМАУ энхийг эрхэмлэгч хүчний эгнээнд мөр зэрэгцэн зогсож, олон улсын тулгамдсан асуудлуудад нэг байр сууринаас хандаж байдагт сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлэхийг хүсч байна. Найрамдалт Монголд хийж байгаа бидний энэхүү айлчлал манай хоёр ард түмний ах дүүгийн хэлхээ холбоог бэхжүүлэхийн хамт даян дэлхийд энх тайван, тогтвортой байдал, хамтын ажиллагааны төлөө хүчний фронтыг цаашид улам бэхжүүлэхэд нааштай үүрэг гүйцэтгэнэ гэж итгэж байгаагаа илэрхийлье»<sup>13</sup> гэсэн юм.

Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийн тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Афганистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Д. Содном, ААН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНАфГУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга С. А. Кештманд нар 1987 оны долдугаар сарын 10-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурав. Мөн БНМАУ-аас БНАфГУ-д эдийн засгийн нэмэгдэл буцалтгүй тусламж үзүүлэх тухай БНМАУ, БНАфГУ-н Засгийн газар хоорондын хэлэлцээрт БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга М. Пэлжээ, БНАфГУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Мухаммед Хаким нар гарын үсэг зурсан билээ.

Монголын ард түмэн, ах дүү Афганы баатарлаг ард түмэнтэй эв санааны гүн нэгдэлтэй байж, тэдний шударга ариун үйл хэргийн талд зогсож байна. МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ж. Батмөнх МАХН-ын XIX их хурал дээр хэлсэн үгэндээ: «Дөрөвдүгээр сарын хувьсгалын ололтоо хамгаалж, харгис хүчнээс тасралтгүй явуулж байгаа зэвсэгт халдлагын эсрэг зориг бадрангуй тэмцэж байгаа арганы ард түмний талд БНМАУ бат зогсож байна»<sup>14</sup> гэж онцлон тэмдэглэсэн юм.

Улс орондоо үндэсний эвлэрэл тогтоон, хөрш орнуудтай найрсаг харилцаа бэхжүүлэх замаар энх тайван хөгжлийн цагийг хангах гэсэн Бүгд Найрамдах Афганистан Улсын нам, засгийн газрын бодлого, тус орны эргэн тойрны байдлыг улс төрийн аргаар зохицуулан, бүрэн бүтэн байдлыг хангах найдвартай баталгаа бий болгох гэсэн ЗСБНХУ, социалист бусад орны үйл ажиллагаа, нөгөө талаас бүрэн эрхт Афганистан орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох явдлаа улам эрчимжүүлж, энд арваад жил үргэлжилж байгаа дайныг өргөжүүлэх гэсэн өрнөдийнхөн, юуны өмнө АНУ-ын эрх баригчдын түрэмгий бодлого сөргөлдөж байгааг олон улсын харилцаанд болсон үйл явдал нотолж байна.

«НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын бие төлөөлөгчөөр зуучлуулан хийж буй Афган-Пакистаны хэлэлцээн дээр бүхэлдээ таатай нөхцөл байдал бүрэлдэж байгаа нь афганы асуудлын гадаад талыг улс төрийн аргаар шийдвэрлэх үйл явцыг даруй дуусгах итгэл найдвар төрүүлж байна. Афганы тал энэ хэлэлцээний ээлжит үед үр бүтээлтэй бэлтгэж, зохих тохиролцоонд хүрэхийг эрмэлзэж байна»<sup>15</sup> гэж ЗХУКН-

ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, ЗСБНХУ-ын Гадаад явдлын яамны сайд Э. А. Шевардназе БНАфГУ-д 1988 оны 1-р сарын 4-6-нд хийсэн ажлын айлчлалын мэдэгдэлд тэмдэглэсэн билээ.

Афганистаны Засгийн газрын хүсэлтээр тус оронд интернационалч үүргээ нэр төртэй биелүүлж байгаа Зөвлөлтийн хязгаарлагдмал тооны цэргийг 1988 оны тавдугаар сарын 15-наас эхлэн арван сарын дотор гаргаж дуусах тухай тодорхой хугацааг Зөвлөлт, Афганистаны удирдлага тохиролцон мэдэгдэл хийснийг дэлхийн улс түмэн талархан сайшааж байна. Хамтын энэ шийдвэр нь бүс нутгийн хамгийн хүнд хэцүү эгзэгтэй мөргөлдөөнүүдийн нэгийг улс төрийн аргаар зохицуулахад чиглэсэн сайн санааны илрэл мөн.

Афганистаны асуудлаар ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев шинэ чухал санаачилга дэвшүүлснээрээ сүүлийн үед давамгайлж байгаа олон улсын нааштай хандлагыг бататган, дэлхий дахины уур амьсгалыг бүхэлд нь эрүүлжүүлэхэд улс төрийн шинэ сэтгэлгээгээр бодитой хандахын үлгэр дууриал үзүүлэв. ЗХУ, БНАфГУ-ын удирдагчид Афганистанд эвслийн засгийн газар байгуулах нь асуудлын гадаад талын зохицуулалттай холбоогүй гэж мэдэгдсэн чухал зүйл юм. «Бусад улсын дотор эх орон нь чухам ямар статсустай байхыг ч Афганчууд өөрсдөө тодорхойлно. Ирээдүйн Афганистан улс тусгаар тогтносон, эвсэлд нэгдээгүй, төвийг сахисан улс байх болно гэж олонтаа ярьж байна. Бид ч өмнөд хил дээрээ тийм хөрштэй байвал гагцхүү баярлах болно»<sup>16</sup> гэж ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев мэдэгдсэн билээ. БНАфГУ-ын ерөнхийлөгч Нажибулла мэдэгдэхдээ: «Зөвхөн афганчууд өөрсдийн орны хувь заяаг тодорхойлж ирсэн, тодорхойлж ч байна»<sup>17</sup> гэжээ.

Олон улсын ач холбогдолтой энэхүү баримт бичигт Афганистаны асуудлыг шийдвэрлэсэн нь зөвхөн Афганы ард түмний хувь заяа, эрх чөлөөтэй амьдрах асуудал төдийгүй бөмбөрцгийн бусад хэсэгт гарч буй зөрчил тэмцлийг улс төрийн аргаар зохицуулахад чухал нөлөө үзүүлэх ёстойг Зөвлөлтийн удирдагч тодорхойлсон байна.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын бие төлөөлөгчийн оролцоотойгоор Женевт болж байгаа Афганистан, Пакистаны хоорондын хэлэлцээ бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, Пакистанаас афганис таны дүрвэгчдийг буцаах, Афганистан улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох явдлыг хангах, тэдгээр асуудалд тавих хяналтыг тогтоох тухай баримт бичгийг боловсруулах ажил бараг төгсгөлийн шатандаа ороод байна. Уг хэлэлцээрийг аль болох хурдан, амжилттай дуусгахад дөхөм үзүүлэхийн тул зөвлөлтийн цэргийг афганистаны нутгаас 1988 оны 5 дугаар сарын 15-наас гаргаж эхлэхээр Афганистаны Засгийн газартай ЗХУ-ын Засгийн газар хэлэлцэн тохирсон билээ. Афганистан дахь цэргийн мөргөлдөөнийг улс төрийн аргаар зохицуулахад чиглэсэн Зөвлөлтийн энх тайванч шинэ санаачилгыг дэлхий дахинд улс төрийн шинэ сэтгэлгээ, өнөөгийн ертөнцийг шинээр үзэж байгаагийн нотолгоо гэж өндөр үнэлж байна.

Үндэсний эвлэрлийн бодлого тодорхой амжилтад хүрч байгаа боловч түүний гол зорилго-дайныг зогсоох зорилгыг хэрэгжүүлэхэд АНУ-ын зүгээс эсэргүү зэвсэгт бүлгүүдэд үзүүлэх тусламжаа үргэлжлүүлж, мөргөлдөөний голомтыг дэвэргэх бодлогоосоо үнэн хэрэгтээ ухраагүй байгаа явдал саад учруулж байна. Өнгөрсөн санхүүгийн жилд АНУ

Афганы хувьсгалын эсэргүү хүчинд 630 сая доллар, түүнчлэн 600 «Стингер» пуужинг олгоод байна,<sup>18</sup> далд өгсөн тусламж нийтдээ 1,5 миллиард болоод байна. 1988 оны эхээр ерөнхийлөгч Рейган хувьсгалын эсэргүүчүүдэд явуулсан илгээлтдээ цэрэг-улс төрийн тусламжаа нэмэгдүүлнэ гэж амлажээ. Чухамдаа зөвлөлтийн хязгаарлагдмал тооны цэргийг Афганистанаас гарахад Вашингтоноос Афганистаны хувьсгалын эсэргүүчүүдэд үзүүлсээр байгаа цэргийн тусламж, тус орны байдлыг хурцатгах гэсэн өрнөдийнхний оролдлого саад болж байна. БНАфГУ-ын эсрэг империализм, харгис хүчний явуулж байгаа зарлаагүй дайны уршгаар тус оронд асар их хохирол учирчээ. Олон арван үйлдвэрийн газар, цахилгаан станц, цахилгаан нэвтрүүлгийн шугамын ихээхэн хэсэг, 14 мянган километр телефон-телеграфын шугам, мөн түүнчлэн усжуулалтын барилга, гүүр зам, тээврийн хэрэгсэл, сургууль, эмнэлэг, сүм дуган эвдэрч сүйрсэн юм. Одоогийн байдлаар УААА-д учирсан эдийн засгийн шууд хохирол 50 миллиард афгани буюу 1 миллиард долларт хүрээд байна. АНУ-аар толгойлуулсан барууны улсуудын үзүүлж байгаа эдийн засгийн хяналтын улмаас улсын худалдаа, төлбөрийн балансын гарз үлэмж нэмэгдэж (бараа гүйлгээний хэмжээний бараг 20%, түүнчлэн улсын алтан валютын сан хорогдлоо. Вашингтоныхон Пакистанд үзүүлэх цэргийн тусламжаа нэмэгдүүллээ. Саяхан АНУ-ын конгресс ирэх санхүүгийн жилд Пакистанд цэрэг эдийн засгийн тусламж үзүүлэх шийдвэр гаргажээ. Түүний дагуу АНУ цөмийн зэвсэг тээх чадалтай «Ф—16» бөмбөгдөгч онгоц, «Стингер» пуужингийн шинэ төрөл, бусад олон тооны зэвсэг нийлүүлэх юм. АНУ ын төрийн нарийн бичгийн даргын орлогч М, Армакост Пакистаны ерөнхийлөгчтэй уулзахдаа үүнийг дахин нотолсон байна.

Өрнөдийн орнууд болон Пакистаны төлөөлөгчид сөргөлдөх байр суурь баримтлан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 42-р чуулганд Афганистаны эргэн тойрны байдлыг хэлэлцүүлэх тогтоол оруулсан юм. БНАфГУ, ЗХУ, БНМАУ социалист бусад орнууд, эвсэлд нэгдээгүй хэд хэдэн орны төлөөлөгчид энэ тогтоолыг эсэргүүцэв. Энэ тогтоол нь Афганистаныг тойрсон үйл явцыг бодит байдалд нийцээгүй, тэнд бий болсон байдлыг улс төрийн аргаар зохицуулах асуудлыг тусгаагүй юм. БНАфГУ-ын эсрэг зарлаагүй дайныг цаашид үргэлжлүүлэх сонирхолтой харгис хүчнүүдийн хууль бус үйл ажиллагааг зөвхөн халхавчлах үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Улс орныхоо орчин тойрны байдлыг улс төрийн аргаар зохицуулах, үндэсний эвлэрэл тогтооход чиглэсэн АААН, БНАфГУ-ын санаачилгыг манай гаригийн энхийг эрхэмлэгч, дэвшилт хүчин талархан дэмжиж байна. Олон улсын харилцаанд сүүлийн үед гарч байгаа нааштай өөрчлөлтүүд энэхүү асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх сайхан угтвар нөхцөл бий болгож байна,

АААН, БНАфГУ-ын Засгийн газар үндэсний эвлэрлийн чиг шугамыг тунхагласнаас хойшхи цаг хугацаа нь энэхүү үйл явцаас өөр сонгох зам байхгүй гэдгийг нотлон харуулж байна гэдгийг өнгөрсөн оны

18-20-нд хуралдсан АААН-ын нийт үндэсний бага хурал тодорхой заасан билээ. ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орон, түүний дотор БНМАУ үндэсний эвлэрлийн бодлогын ач холбогдлыг өндрөөр үнэлж, түүний үйл явц нь эргэлт буцалтгүй болно гэдэгт итгэл төгс байна.

<sup>1</sup> «Үнэн 1987—1—3

<sup>2</sup> АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987. (дари хэлээр)

<sup>3</sup> «Үнэн» 1988-1-16

<sup>4</sup> АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987. (дари хэлээр)

<sup>5</sup> Мөн тэнд 5а Kabul new times. October 20. 1987

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> Kabul new times. October 20—22. 1987

<sup>8</sup> Kabul new times. October 22. 1987

<sup>9</sup> АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987 48- хуудас  
дари хэлээр)

<sup>10</sup> Мөн тэнд

<sup>11</sup> Kabul new times. October 21. 1987

<sup>12</sup> Азия и Африка N 12 (1987), с. 27

<sup>13</sup> Үнэн 1987—7—8 N 162

<sup>14</sup> Ж. Батмөнх, МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны  
тайлан, цаашдын зорилт. УБ. 1986, 15-р тал

<sup>15</sup> «Үнэн» 1988— —8

<sup>16</sup> «Үнэн» 1987—11—10

<sup>17</sup> Мөн тэнд

<sup>18</sup> Consultative meeting of representatives of the communist and worker's parties  
of Asian and Pacific region countries. UB. 1987. p. 106.

БНХАУ ДАХЬ  
ШИНЭТГЭЛ

ХКН-ЫН ХШ ИХ ХУРАЛ

Д. ШҮРХҮҮ

ХКН-ын ээлжит ХШ их хурал 1987 оны 10-р сарын 25-наас 11-р сарын 1-нд Бээжин хотноо хуралдав. Энэ их хурал нь нэлээд урт хугацаанд ХКН-аас улс төр, нийгэм-эдийн засаг, гадаад бодлогын салбарт баримтлах үндсэн чиг шугам, шинэтгэл, нээлттэй хаалганы бодлогыг цаашид гүнзгийрүүлэн түргэтгэх арга зам, эдийн засгийг хөгжүүлэх стратегийн чиглэлийг тодорхойлон зааснаараа онцлогтой юм.

46 сая гишүүдийг төлөөлсөн 2000 орчим төлөөлөгчид ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Жао Зыяны тавьсан Төв Хорооны тайлан илтгэл, ХКН-ын ТХ-ны Зөвлөхүүдийн